



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 06 сарын 21 өдөр

Дугаар 82

Номгон

**Зөрчлийн улмаас хураагдсан тээврийн хэрэгслүүдийг
иргэдэд буцаан шилжүүлэх, худалдах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Цагдаагийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 29-1/1658 дугаар албан бичиг ирүүлсний дагуу зөрчлийн улмаас 2017, 2018, 2019, 2020 онуудад түр саатуулагдсан боловч Зөрчлийн тухай хуульд зааснаар хариуцлага тооцох хөөн хэлэлцэх хугацаа өнгөрч, эзэмшигч иргэд нь түр саатуулах хашааны төлбөрийг төлөөгүй 67 ширхэг мотоцикл, 14 ширхэг автомашиныг түр саатуулах хашааны төлбөрөөс чөлөөлж, эзэмшигч иргэдэд нь үнэ төлбөргүй буцаан олгосугай.

2. Дээрх тээврийн хэрэгслүүдийг эзэмшигч иргэдэд нь үнэ төлбөргүй өгөх, эзэмшигч иргэд нь аваагүй мотоциклийг иргэдэд худалдан борлуулах ажлыг 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 01-ний хооронд зохион байгуулж, хэвлэл мэдээлэл, олон нийтийн хэрэгслээр сурталчилж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

3. Эзэд нь аваагүй мотоциклын 1 бүрийн үнийг 50.000 төгрөгөөр, автомашин тус бүрийг зах зээлийн үнээр тус тус худалдан борлуулсугай.

4. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил гаргасан иргэдийн саатуулагдсан тээврийн хэрэгслийн хөөн хэлэлцэх хугацааг дуусахаас өмнө тухай бүр хуулийн дагуу шийдвэрлэж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа (Б.Оюутболд)-д даалгасугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ө.ЭНХБАТ



0121138